

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,
ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 03 дугаар сар 24 өдөр

Дугаар 73 А/66.

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Жолоочийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Жолоочийн даатгалын баталгааны загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Журам батлах тухай” А/22/23 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Ц.Энхбаяр/, Цагдаагийн ерөнхий газар /Р.Чингис/, Албан журмын даатгагчдын холбоо /Д.Цэвээнжав/-нд тус тус даалгасугай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА



ХУУЛЬ ЗҮЙН САЙД



Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүйн
сайдын 2015 оны 03 дугаар сарын 24 өдрийн 73.../66
дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЗАГВАРЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын баталгаа /цаашид “даатгалын баталгаа” гэх/-ны загварыг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Даатгалын баталгаа

2.1. Даатгагч гарын үсэг зурсан Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ /цаашид гэрээ гэх/-нд жолоочийн даатгалын мэдээллийн сангаас олгогдож буй гэрээний дугаар нь жолоочийн даатгалын баталгаа болно.

2.2. Даатгагч Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг жолоочийн даатгалын мэдээллийн санд бүртгүүлж гэрээний дугаар авна.

2.3. Даатгагч, техникийн хяналтын үзлэг оношлогооны байгууллага, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч, даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч нь цахимаар болон шалгах төхөөрөмж ашиглан даатгуулагчийн даатгалын гэрээг хүчинтэй, даатгалын баталгаатай эсэхийг жолоочийн даатгалын мэдээллийн сангаас шалгана.

2.4. Даатгуулагч нь даатгагчтай болон даатгалын зуучлагч компаниар зуучлуулан хийсэн даатгалын гэрээний баталгаатай эсэхийг Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас цахимаар хянаж болно.

2.5. Даатгалын гэрээний баталгаатай эсэхийг энэ журмын 2.3-д заасан байгууллага, албан тушаалтан жолоочийн даатгалын мэдээллийн сангаас цахим хэлбэрээр хянах боломжийг Албан журмын даатгагчдын холбоо бүрдүүлж өгнө.

Гурав. Бусад

3.1. Энэ журмын биелэлтэд Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч нар хяналт тавьж ажиллана

--oo0oo--

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүйн сайдын 2015 оны 03 дугаар сарын 24 өдрийн 73/А/66 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЗАГВАР

1.1. Жолоочийн даатгалын баталгаа нь дараах арван дөрвөн орон бүхий тоон мэдээллийг агуулсан загвартай байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14

1.2. Гэрээний дугаарын эхний 2 тоо нь тухайн оны сүүлийн 2 тоог, 3, 4 дүгээр тоо нь Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын компанид олгосон ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаарын сүүлийн 2 тоог, 5-9 дүгээр тоо нь тухайн гэрээг хийсэн даатгагчийн хувийн дугаарыг, 10-13 дугаар тоо нь тухайн даатгагчийн хийсэн, даатгалын зуучлагчийн зуучилсан гэрээний жолоочийн даатгалын мэдээллийн санд хугацааны дарааллаар эрэмбэлэгдсэн дэс дугаарыг илэрхийлнэ. 14 дүгээр тоо нь гэрээний төрлийг заана.

Гэрээний төрлийг дараах байдлаар тэмдэглэнэ. 1-ийн тоо нь хувь хүн, 2-ын тоо нь аж ахуйн нэгж, 3-ын тоо нь мэргэшсэн жолооч, 4-ийн тоо нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчтэй хийсэн гэрээ болохыг илэрхийлнэ.

--oo0oo--